

МЭДЛЭГТ ТУЛГУУРЛАСАН ҮЙЛДВЭРЛЭЛ – МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Бид яагаад өнөөдрийг хүртэл зөвхөн байгалийн эрхшээлд байдаг мал аж ахуй, байгалиа сүйтгэхэд нэмэр болдог газрын баялагт шүтсэн аж ахуйгаас өөр зүйлд анхаарал тавихгүй байна вэ? Манай орны хөгжлийн үндэс нь хэдхэн мянган тонн ноолуур, ноос түүнийг тойрсон хэрүүл маргаан, “яндаж болшгүй далай шиг” гэж дуулж ирсэн ч яахын аргагүй шавхагдах эрдэс баялгаас өөр зүйл байх боломжгүй гэж үү?

Тиймээ монголчуудынхаа сэргэлэн ухаанд дулдуйдаж, залуусынхаа сэтгэл зоригийг татаж, боловсрол мэдлэгийг нь өөд татахад хөрөнгө оруулалтыг зоригтой хийж, нүүдлийн биш суурин аж ахуйд шилжин, биеийн бус оюуны хөдөлмөрийг шүтэж, “цагаан захтны” армийг олшруулах замаар монгол орноо хөгжүүлэх тухай сэтгэдэг адын гэмээр бодолтой хүмүүсийн нэг нь би болохоор үүнийг бичиж сууна.

Дэлхий даяар мэдээллийн нийгэмд ажиллаж амьдрах цаг ирлээ гэцгээн улс орон бүр түүнд зохицох бодлогоо тодорхойлж, бодит алхмууд хийж эхлээд байхад монголчууд бид хэдий болтол ядуугаараа гайхуулж, зуд турханаа суртчилж, элдэв осол сүйрлээ бүхний сонорт хүргэж, хэдэн бор юм салгах маягаар төсвийн алдагдлаа нөхөн суусаар байх билээ. Хамгийн гайхалтай нь энэ бүх мэдээлэл цахилгаан мэт хурдан тархахад нөгөө л “мэдээллийн технологи” гэдэг зүйлээ ашиглаад байгаагаа ч анзаарч байгаа билүү гэж өөрөөсөө болоод өрөөлөөс асуумаар санагдаад болохгүй юм.

Ердөө л арваадхан жилийн өмнө европын өндөр хөгжилтэй орнууд дотроо хоцрогдсон, ядуу гэгддэг байсан Ирланд улс өнөөдөр оюун шингээсэн экспортын бүтээгдхүүний нийлүүлэлтээрээ толгой цохисон, эдийн засаг нь эрс сайжирсан орны нэг болж, өнөөдөр европын зах зээлд борлуулагдсан нийт програм хангамжийн бүтээгдхүүний 65%-ыг нийлүүлэгч болсон статистик байгаа нь бидэнд нэгийг хэлээд байгаа юм биш үү.

Тэгэхээр юуны тухай бичиж байгаагаа тодотгоё.

Үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжсэн нийгэмд шилжин орж байгаа энэ үйл явц дэлхийн эдийн засгийн зах зээлд нэгэн шинэ боломж, орчинг бий болгож байна. Энэ зах зээлд эрэлт хэрэгцээ огцом өссөнөөс нийлүүлэлтийн хурд нь гүйцэхгүй болж хомсдол үүсэн мэдээллийн технологид суурилсан ажил үйлчилгээг импортлох явдал нэмэгдэж, үйлдвэрлэл нийлүүлэлтийн зах зээлийн амсар нээгдэж, асар өргөн боломж үүсээд байгаа юм. Дэлхийн хөгжилтэй орнууд мэдлэгт тулгуурласан бүтээгдхүүн, электрон хэлбэрийн ажил үйлчилгээгээр дутагдаж байгаа төдийгүй, мэдээллийн технологийн мэргэжилтнээр гачигдаж байгааг АНУ-д 200 мянга гаруй “ногоон картыг” гадаадын өндөр мэргэшилтэй мэргэжилтнүүд тэр дундаа Мэдээллийн Технологийн мэргэжилтнүүдэд зориулан гаргахаар хэлэлцэж байна. Энэ эрхийг авсан хүн 7 жил хүртэлх хугацаагаар технологийн салбарт америк хүний нэгэн адил ажиллах боломжтой болох юм. Мөн гаднаас ажиллах хүч хүлээн авахдаа хатуу чанга гэгддэг Герман улс гэхэд л 2000 оны 4-р сараас 20 мянган “ногоон карт” буюу 5 жил хүртэл хугацаагаар ажиллаж амьдрах визийн зөвшөөрлийг зөвхөн Мэдээллийн Технологийн мэргэжилтнүүдэд олгохоор шийдвэрлэсэнээ зарласан билээ. Энэ хоёр жишээ л хэрэгцээ хэр байгааг нотлоод өгнө.

Тэгвэл энэ хэрэгцээг соргоогоор мэдэрч энэ чиглэлийн үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлж, эдийн засгаа өөд нь татаж буй орнуудын тэргүүн эгнээнд Энэтхэг,

Ирланд, Филиппин яваа бөгөөд түүний араас Египет, Малази, Унгар, Чех, Болгар зэрэг орон буухиалж явааг Гартнер Групп (GartnerGroup) –ээс гаргасан судалгаанаас харж болно.

Энэтхэг улс програм хангамжийн үйлдвэрлэлээр дэлхийн зах зээлд өрсөлддөг 500 гаруй компанитай бөгөөд ердөө 20 компани нь нэг млрд доллароор хэмжигдэх орлогын 60 хувийг хийдэг байна. Жил бүр 60 гаруй мянган мэдээллийн технологийн мэргэжилтэн бэлтгэгдгээс 25 хувь нь зөвхөн програм хангамжийн чиглэлд бэлтгэгддэг. Энэ үйл ажиллагааг засгийн газар нь төрөл бүрийн бодлогоор дэмжиж, Энэтхэгт үйл ажиллагаагаа эхлэх, эрхлэхэд маш хялбар, энгийн байх хууль, тогтоомж, дүрэм журмаар хангаж, татварын төрөл бүрийн урамшуулал, импортын татвараас чөлөөлөх, экспортын чиглэлээр ажиллах зориулалттай технологийн парк байгуулах зэрэг бодит туслалцааг үзүүлдэг байна. Энэтхэг бол дэд бүтцийн хувьд цахилгаан, холбоо, тээврийн асуудал гээд л манайд байдаг проблем байдаг л газрын нэг. Харин давуу тал нь англи хэлтэй, ажил хэргээ энэ хэл дээр хөтлөн явуулдаг.

Ирланд програм хангамжийн үйлдвэрлэлийн хэмжээгээр дэлхийд АНУ-ын дараа 2-т ордог, жилдээ 5 млрд долларын бүтээгдхүүн үйлдвэрлэдэг. Энэ салбарт 15 мянган хүн ажилладаг нь европын зах зээлд гаргадаг бүтээгдхүүний ихэнхийг үйлдвэрлэдэг бөгөөд жилд 600 сая долларын экспорт хийдэг байна. Ирландад 400 гаруй програм хангамжийн компани байдгаас 100 гаруй нь улс дамнасан том компани. Мэдээллийн технологийн үйлчилгээний салбарт 50 орчим компани ажилладаг. Хамгийн сонирхолтой нь цөөхөн хэдэн компаниуд л 150-иас дээш ажилтантай байдаг. Хэлний хувьд мэргэжилтнүүд нь хэд хэдэн хэл мэддэгээрээ онцлог. Харин цалингийн хэмжээ нь Энэтхэг, Филиппинтэй харьцуулахад хамаагүй өндөр. Энэ нь хямд зардал дээр түшиглэх сонирхолтой компаниудын хувьд тааламжтай зүйл биш юм.

Филиппины хувьд 3000 гаруй компани байдаг ч ихэнх нь 50-иас доош тооны ажилтантай байдаг. Экспортын чиглэлд 60-аад компани л ажилладаг. Ажиллах хүчний тоо энэ салбарт 20-30 мянга орчим байдаг. Түүнээс гадна 10 мянган мэргэжилтэн гадаадад ажилладаг. Жилд 17 мянга орчим хүн мэдээллийн технологийн чиглэлд төгсдөг ч проектын сайн удирдагч, удирдах ажилтан дутагдалтай гэж үздэг байна. Ажиллах хүчний үнэ Энэтхэгтэй харьцуулахад өндөр ч, Америктай харьцуулахад маш бага байдаг нь давуу тал. Хэлний бэрхшээл бизнес, дээд боловсролын хүрээнд байдаггүй.

Хэдийгээр Канад, Мексик улсууд захиалгат программын бүтээгдхүүн үйлдвэрлэлтээр энэ зах зээлд байр сууриа аль хэдийн олчихсон, Америкийн зах зээлд хамгийн ойр оршдог, хэлний бэрхшээлгүй зэрэг олон давуу талтай ч ойрын ирээдүйд ялангуяа Канад улс өөрсдийнхөө дотоод хэрэгцээнд дарагдах магадлал ихтэй байгаа учир экспортын зах зээл дээр гарах боломжгүй.

Хятад мөн Мэдээллийн технологийн салбартаа үсрэнгүй алхам хийж, 2001 оны эцэс гэхэд компьютерийнхээ тоогоор Япон улсыг гүйцэж түрүүлэх прогноз байгаа ч мөн л дотоод хэрэгцээгээ хангахад илүү анхаарал тавина. Мэргэжилтнүүдийн тооцоолсноор Хятадад ойрын жилүүдэд Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийн зах зээл нь 6.4 млрд долларт хүрэхээс 3.4 млрд нь програм хангамжийн үйлдвэрлэлд ногдох юм байна. 2010 он гэхэд Хятадын мэдээллийн зах зээлийн хэмжээ АНУ-аас ч давах тооцоог судлаачид гаргажээ.

Тэгвэл бид юу хийх хэрэгтэй вэ?, магадгүй хэдэн зуун жилд ганц тохиолдон буй алтан хором ч байж магадгүй энэ боломжийг хэрхэн ашиглах вэ, монголчуудад ядуурлаасаа салах, эдийн засгаа хүчирхэгжүүлэх боломж олдсон юм биш биздээ гэдэгт нийлээд толгойгоо гашилгацгаая.

Зарим нь бид мөнгөгүй, энэ салбарт мэдлэг туршлага багатай, зах зээлээсээ алс хол байршилтай, цөөхүүлхнээ гэх мэтийн зовлон байхад юугаа яриад байна вэ гэх байх л даа.

Энэ салбарын онцлог нь газар зүйн байршил бараг нөлөөлдөггүй, гол суурь дэд бүтэц нь интернэт, компьютер, мөн хүний оюуны чадавхи мэдлэг дээр голлон тулгуурласан байдаг л оршино. Азаар ч гэхүү бид аль 1994 онд интернэтэд холбогдсон нь тухайн үедээ эргэн тойрныхоо орнуудаас хол түрүүлсэн хэрэг байсан. Тэр үед хувийн хэвшлийн нэг компани л энэ тухай монголчууддаа тайлбарлан ойлгуулах гэж, бизнес болгох гэж ядаж байсан бол өнөөдөр аль хэдийн 5-6 интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид бий болж, хэдэн арван байгууллагууд эхлэх тухай ярьцгааж, ядаж л имэйл гэгчийн ид шидийг мэддэг хүн олширсон. Өнөөдөр Улаанбаатарт байгаа мэргэжилтний ажиллах техникийн суурь боломж, орчин нь Энэтхэгт эсвэл Германд байгаа мэргэжилтнийхтэй адил түвшинд байгаа. Харин боловсон хүчний бэлтгэл, мэдлэг бол тусдаа асуудал, гэхдээ үүнийг шийдэхэд хэцүү биш.

Харин мэдээллийн технологийн ид шид, боломжийг имэйл, вэб мэтээс дахин нэг алхамын цаана харах асуудал ахиад л учир дутагдалтай хэвээр байна. Үүнийг залруулахын тулд юу хийх вэ? Гэхдээ эхэлж бодохоосоо өмнө “Эвт шаазгай буга барина” гэдэг үгийг сануулчихаад үргэлжлүүлмээр байна. Бид зөв сэтгэж, хамтаараа хийвэл өөрөөр хэлбэл дээр дооргүй, засаг төр маань ч, эрдэмтэн судлаачид ч, мэдээллийн технологийн салбарт ажилладаг хувийн хэвшлийн үйлдвэрлэгчид (тэд гол хөдөлгөгч хүч байсан, байгаа, байх ч болно!), боловсролын салбарын байгууллага түүний дотроос их, дээд, дунд сургуулийнхан ч тэр хамтран нэгэн зорилгын дор бодлогоо зангидаж эхэлмээр байна. Магадгүй бид “мянганы зам” гэснээс “мянганы мэдээллийн зам”-ын төлөө хөрөнгө хүчээ, сэтгэл зүтгэлээ зориулвал хэдэн зуу дахин бага зардлаар илүү ихийг хийж, эдийн засгаа бэхжүүлж, бусдаас гуйлгачилахгүй амьдрах ч юм билүү, жинхэнэ “мянганы зам”-аа босгох өөрийн мөнгөтэй болох ч юм билүү.

Монголчууд маань хоорондоо их атаархуу ч юм шиг, бие биенээ дууриамтгай ч юм шиг улс (яагаав нэг нь ТҮЦ барихаар нөгөө нь дууриадгаас өнөөдөр байр болгоны араар, буудлын дэргэдүүр амбаарын цуглуулгатай болчихсон шиг!) зөв зүгт түүнийгээ залвал “хүрэхгүй газар, чадахгүй зүйлгүй” ч байх боломжтой шүү дээ. Харин нэг нь нөгөөгөөсөө мэдээллээ нууж, би өөрөө л гэдэг хүслээ дараад, нийлж ажилланаа гэдгээ анхнаасаа бат ойлгох ёстой юм. Нэг ёсондоо нийлүүлэх зах зээл хангалттай байна, харин халбага халбагаа биш, хамтран хутгах шанагаа бэлдэх, үүний тулд юу хийх вэ гэдгээ л бодох хэрэгтэй байна гэдгийг дараах тоо баримтаас хялбархан ойлгож болно:

Наском (NASSCOM)-ын судалгааг үзэхэд Америкийн мэдээллийн технологийн зах зээлд гэхэд л гадаадаас захиалгаар хийлгэх (Offshore outsourcing), үйлчлүүлэх шаардлагатай байгаа ажил үйлчилгээнээс зөвхөн програм хангамжийн бүтээгдхүүний хэмжээ жилд 100 млрд доллар орчим байгаа, энэ нь жил тутамд 30%-иар өсөх хандлагатай юм байна. Энэ чиглэлд тэргүүлж байгаа Энэтхэгийн экспорт 1.1 млрд долларт хүрсэн, энэ нь жилд 50%-иар өсдөг гэж дурджээ. Мөн өөр нэг эх үүсвэр Датакүэст (Dataquest)-ийн гаргасан судалгаагаар мэдээллийн

технологийн салбарын гадаад захиалгын хэмжээ 2000 онд 143.7 млрд доллар хүрнэ, энэ нь 2003 он хүртэл жил тутам 23%-иар өснө гэсэн байна.

Тэгэхлээр “би л ганцаараа амжуулчих юмсан, хийчих юмсан, баяжих юмсан” гэж сандрах хэрэггүй нь ойлгомжтой байгаа биздээ. Дээр нь бас энэ чиглэлийн үйлдвэрлэл бол ердийн ганзагын наймаа шиг “гахайгаа” үүрээд л ганцаараа жирийгээд л хийчихдэг, эсвэл ямар ч үнээр хамаагүй худалдаж авчраад, суурилуулаад л хэнийг ч юм ажилчнаар элсүүлээд бүтчихдэг зүйл биш гэдгийг санахад илүүдэхгүй.

Энэ салбарт ажиллахад тодорхой түвшинд хүрсэн мэдлэгтэй байх ёстой. Үүнийг алсын хараатай бодлогоор шийдэх хэрэгтэй байгаад гол нь оршино. Гэхдээ дандаа мундаг эрдэмтэн, эсвэл програм зохиогчдын хийх ажил байгаа ч юм биш. Энд жирийн ажилтнаас эхлээд проектын сайн удирдагч, энэ салбарын онцлогийг ойлгодог, удирлагын урлагийг эзэмшсэн дарга ч хэрэгтэй.

Мэдлэгт тулгуурласан ажил үйлчилгээнд компьютер ашиглан, интернэтээр дамжуулан хийж болох бүхий л төрлийн ажил (бичээч, оператор, орчуулагч ч байсан болно) буюу электрон-ажил үйлчилгээ, програм хангамжийн бүтээгдхүүний үйлдвэрлэл, ажиллах хүчний экспорт (хар ажлын биш шүү!) зэрэг бүгд л багтана.

Энэ чиглэлд амжилт олохын тулд юу хийх вэ гэдэг дээр хүмүүсийг эргэцүүлж бодоод өөр өөрийн саналаа нэмэрлээсэй, бүр маргалдаж хэлэлцээсэй гэж бодоод цөөн хэдэн саналаа бичие.

1. Мэдээллийн технологийн чиглэлд үйл ажиллагаа эрхэлж буй, эрхлэхээр шийдэж хөрөнгө оруулалт хийж байгаа байгууллагыг татвараас 3 жил чөлөөлье, хэрэв энэ хугацаанд экспортод ажил үйлчилгээгээ гаргаж эхэлвэл дараагийн 2 жилд нь дахин чөлөөлье.
2. Бүх төрлийн компьютер, түүний төрлийн төхөөрөмжүүд, тэдгээрийн дагалдах хэрэгслийг гаднаас оруулах, нийлүүлэх, худалдахад тэг татвартай болгоё.
3. Орон нутагт ажлын байр нээхээр шийдсэн бол элдэв тусламжийн (ядуурлын сан ч гэдэг юмуу) сангаас хөнгөлөлттэй зээл олгоё.
4. Гадаадын зээл тусламжийн тодорхой хэсгийг мэдээллийн технологийн чиглэлийн сургалт явуулах сургууль, коллеж байгуулах, оюутны солилцоонд, сургагч багш нар бэлтгэхэд, сурах бичиг гарын авлага бэлдэх, орчуулахад зориулья.
5. 2003 он гэхэд Монгол улсын бүх сумдын сургуульд 10-15 компьютертай анги байгуулж өгье. Цахилгааны асуудлыг нь сум болгоны онцлогт нь тохируулж, нар, салхи, дизель, мотор юугаар байдаг юм, бүх л хэлбэрийн аль нэгээр нь шийдэж болно.
6. Бүх аймгийн төвүүдэд интернэт төвүүд байгуулья. Үүнийг үйлчлэхэд улсын өмчид байдаг холбооны сувгаа хөнгөлөлттэй үнээр эсвэл бүр үнэгүйгээр ашиглуулж болно. Телевизийн сувгийн сул зогсдог хугацааг ч үүнд ашиглах талаар судалж болно. Энэ бол технологийн хувьд боломжтой гэдэг нь нотлогдсон асуудал.

7. Төрийн сангийн зээлээр сургаж байгаа оюутны тал хувийг нь энэ чиглэлд сургая. Төсвийн байгууллагын ажилтны нэг хүүхдийн зардлыг даахдаа энэ чиглэлд суралцуулвал илүү дэмжихээр бодлого зохицуулалт хийе.
8. Ойрын 2-3 жилд одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдээ дахин давтан сургах (ямар чиглэлээр хэнийг хэрхэн суралцуулахаа нэгдсэн төлөвлөгөөгөөр зохицуулж болно) хөдөлгөөн өрнүүлэе. Энэ зардлыг донор байгууллагаас авч болно, элдэв хурал, семинарт явдаг зардлын хагасаас санхүүжүүлж болно.
9. “Оюун далай” (“Ухаалаг төв” ч юмуу, нэрийг нь олж болох биз) төв байгуулья. Тэр нь орчин үеийн тохижилттой, тоногосон байр байх бөгөөд мэдээллийн технологийн гадаад дотоодын компаниудыг урьж байрлуулдаг, эхний хэдэн жилд хөнгөлөлттэй бүх нөхцөлөөр хангадаг, онцгой объект байхаар зохицуулж болно.
10. Дотоодын захиалгат ажлыг үндэсний мэргэжлийн компаниудаараа хийлгэцгээе. Тийм чадавхи, боломж бидэнд бий гэдэгт итгэж болно. “Үндэсний үйлдвэрлэлээ дэмжицгээе!” гэсэн уриа мэдээлэл холбооны технологийн салбарт ч мөн адил үйлчлэх ёстой.

Дээр дурдсан зүйлс бол суурь нөхцөлүүд юм. Жинхэнэ ёсоор мэдээллийн технологийн салбарыг түшиглэн үйл ажиллагаа явуулж, эдийн засгийн үр шимийг нь хүртэхийн тулд дараах нөхцөлүүдийг бүрдүүлсэн байх зайлшгүй шаардлагатай юм. Үүнд:

1. Мэдээллийн технологийн салбарт ажилладаг хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэдгээрийг нарийн мэргэшүүлэх

2000 онд бидний гаргасан судалгаагаар манай улсад мэдээлэл холбооны технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, компанид нийтдээ 12000 гаруй хүн ажилладагаас 600 орчим нь програм хангамжийн чиглэлд ажилладаг гэсэн тоо гарсан. Тэгвэл боловсон хүчний энэхүү нөөцийг зөв чиглүүлэн мэргэшүүлвэл манайд 3-5 жилийн дотор 6000 мэргэжилтнийг бий болгох боломж харагдаж байгаа юм. Энд би жил бүр төгсөх оюутнуудын тоог оруулж тооцсонгүй.

Мэргэжилтнүүдээ нарийн мэргэшүүлэх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд сургаж, сертификатжуулах асуудлыг шийдвэрлэх үүднээс мэргэжил дээшлүүлэх сургалтын төвүүд байгуулж болно. Үүний тулд олон улсын нэр хүндтэй компаниудтай хамтрах замаар тэдний сургалтын төвийг Монголд байгуулах арга замыг ч судалж болох юм.

2. Мэдээллийн технологийн салбарын удирдах боловсон хүчний чадавхийг сайжруулах

Өнөөдөр энэ салбарт ажилладаг компаниудыг толгойлдог цөөн хэдэн мэргэжилтнүүдийг эс тооцвол үйлдвэрлэлийн конвейрийн хэмжээнд оччихсон энэ салбарын үйл ажиллагааг сайн мэдэрдэг, барууны менежементийн ухаанд суралцсан хүн ховор байгаа энэ үед гадаадын мэргэжилтнүүдийг (харин сонгохдоо мэргэжилтнүүдийнхээ тусламжтайгаар сонгох, тэгэхгүй бол нэг дарга сонгосноос ирээд биднээс асуугаад судлаад эхэлдэг хүн хэрэггүй, ийм гашуун туршлага манайд хангалттай бий) урьж ажиллуулах, манай менежерүүдийг дагалдуулан сургах замаар шийдэж болно. Мэдээллийн технологийн салбарт тэргүүлдэг хүмүүсээр баг байгуулж, “сэтгэх хүч” маягийн цөм бий болгож, хамтран ажиллах.

Үүний хажуугаар үндэсний менежерүүдээ нарийн мэргэшлийн сургалтанд хамруулах.

3. Ажлын үнэлэмжийг зөв тогтоох

Бид гадаад зах зээл дээр бусадтай өрсөлдөхийн тулд үнэлэмжийг зөв тогтоох хэрэгтэй. Тэрнээс биш зүгээр л тэнд тэдэн мянган доллар авдаг гэсэн бид ч бас гэх маягаар хандах хэрэггүй. Учир нь гадаадад захиалж байгаагийн нэг шалтгаан нь харьцангуй хямд ажиллах хүчинд тулгуурлахыг хүссэн байдаг оршино.

4. Гадаад зах зээлд хүрэх арга замаа тодорхойлох

Энэ чиглэлд манай хэд хэдэн компаниуд бодитой алхам хийсэн. Монголчууд гадаадын захиалгаар ажил, үйлчилгээ хийхэд боломжтой гэдэг нь харагдсан ч захиалгын хэмжээ ихэссэн үед хүний нөөц дутагдаж байгаа нь ажиглагдсаныг манай мэргэжилтнүүд дурдаж байна. Иймд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, мэргэжилтэн бэлтгэхэд хамтран ажиллах, зах зээлд гарах боломжийг хайх нь чухал байгаа юм.

5. Стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах бэлтгэл хангах

Манай байгууллага, компаниуд ISO9001 болон SEI CMM стандартын шаардлагыг хангах бэлтгэл ажлыг одооноос эхлэх.

гэх мэтчилэн бичээд байвал барагдахгүй тул үүгээр цэглээ.

Хийх ажил асар их байна. Цаг хугацаа биднийг хүлээхгүй. Бид алсын хараатайгаар эвсэж ажиллах л үлдээд байна.

Б.Наранцэцэг
Инфокон ХХК-ийн ерөнхий захирал
2001-02-07